

**ЗОХИОЛЧ Т.СУЛТАНЫ “СҮМБЭР УУЛС” РОМАНД КАЗАХ
ҮНДЭСТНИЙ ЗАН ЗАНШЛЫГ ТУСГАСАН НЬ**

Б. Риза *

Казах үндэстэн өөрөө нүүдлийн соёлтой. Тэрхүү нүүдлийн соёлын салаа мөчир болсон утга зохиол нь морин дэл дээр буй болсон “Амар мэндийг эрэхээс эхлээд зүйр үг, цэцэн үг, оньсого, ертөнцийн гурав, бүүвэйн дуу, үлгэр, домог, хууч, айтыс...” гэх мэт аман зохиолоос бичгийн уран зохиол хүртэл хөгжихдөө казах түмний зан заншлыг тусгасаар ирсэн юм.

Уран зохиолын хэтрүүлэл өгүүлэх, үгүйсгэж, шууд, далд өгүүлэх, төлөөлүүлэн, өөрийн өмнөөс өгүүлэх зэрэг олон аргуудыг олон аргуудыг хэрэглэж уран зохиол, бүтээлээ туурвидаг ажээ. Казах хэлт уран зохиол өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой.

“Келін келгеннен, келед дегені кызык”

“Бэр бууснаас бууна гэсэн сураг нь сонин” гэж хасагууд ярьдгийн адил...¹ [32 тал]

Энэ үг нь одоог хүртэл казах ардын дунд хэлэгддэг бөгөөд үүний утгыг зохиолч Т.Султан алдаатай орчуулсан байна.

Уг санаа нь: “Шинэ бэр буулгаж ирэх үеийн тэр хүлээлт, догдлол, бэлтгэл, цаг мөч, хором бүрийн догдлол”-ын тухай яриа юм. Харин зохиолч романдаа:

“Бэр бууснаас бууна гэсэн сураг нь сонин” гэж оруулсан байна.

Казах хэлт утга зохиолд Зүүд, зүүдний тайлал бас чухал байртай байна. Учир нь казахууд зүүдээ өглөө нь босоод настай хүнд хэлж эерэгээр, сайн тайлуулан түүнийгээ ихэд бэлгэшээдэг.

“Сүмбэр уулс” романд:

“Би урьд шөнө Бектас ахыг цагаан морь унаж, цагаан нөмрөг өмсөн давхиж явна гэж зүүдэлсэн. Манайхан цагаан зүстэй юмыг бэлгэ дэмбэрэлтэй гэлцдэг”² [399 тал] гэсэн нь Монголчууд цагаан юмыг сайн, сайхны илэрхийлэл хэмээн бэлгэшээж, алс холын замд сүүн цацал өргөдөг. Казах түмэн ч нэгэн адил “Цагаан” зүйлсийг сайны бэлгэ тэмдэг хэмээн үздэг билээ. Дээрх зүүдийг казах зүүдний тайллаар тайлбал:

Цагаан морь зүүдэлбэл- үйл хэрэг чинь бүтнэ гэжээ.³ [11 тал]

Казахын ард түмэн бүхий л зүйлийг, ялангуяа сэтгэл хөдлөлөө ихэвчлэн ая дуугаар илэрхийлдэг. Үүнд: “Айтыс буюу Дайралцаан” бас чухал үүрэгтэй. **Айтыс бол:**

* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Утга зохиолын тэнхим, докторант

¹) Султан Т. (1986) Сүмбэр уулс. УБ., Боть 1.32

²) Султан Т. (1990) Сүмбэр уулс. УБ., Боть 2.399

³) (2005) Түс жору түрлери жане казактын ырымдары. Алматы., 11

Мөн тоглож наадахдаа ч дуулдаг заншилтай. Эдгээрийг “Сүмбэр уулс” романд:
“Дараа нь тэд “Сохор тэх” хэмээх тоглоом тоглов. Тоглоомын журам ёсоор тэгшхэн газарт гэрийн бууринаас арай том хүрээ татаж, өөрсдөө хүрээн дунд бөөгнөн зогсоно.Темирбек гараа сарвайн хөлөө зөөж тавин, хүрээний дотогш орсноо:”⁴ [97 тал] гэжээ.

Энэ нь залуус нүдээ боож тоглох тоглоомтой ижил юм.

“Харанхуйд нүд балай
Хазгайд гишгэвэл уучлаарай
Хайрыг булаасан чи минь
Хаана байна гэнээ?...” гэхэд хариуд нь:
“Сохор тэх ээ! Сохор оо!
Совин татаад байвал
Солгой талдаа ойрхон

Содон намайг бариач хө!хэмээн хөхөрч Жанибекийн ард нь нуугдав.⁵ [97 тал]

Казах ёсонд байдаг, одоо хүртэл байсаар байгаа нэгэн заншил бол хонь гаргахдаа заавал алгаа дэлгэж бэлгэдлийн үг хэлдэг ёс билээ. Үүнийг дээрхи романд:

“Их насалсныг биш, их юм үзсэнийг сонс гэдэг ардын уламжлалт үг бий. Миний өмнөөс бэлэгдлийн үг, мэргэн сургаалаа хайрла, дүү минь? Өвгөн ах нь зөвшөөрье гэж хэлэв. Касымов ч бэлэн цэцэн үгтэй, ил цагаан хүн аж. Тэр бодолхийлж сууснаа:

-Зээ

Элдэв учрал бүрдсэн
Эв найрамдуу жаргасан
Энэ сайхан өдөр нь
Эрхт гэгээн төрийн
Элбэрэл ачлал дор
Эгнэгт жарган өөдлөх
Эрхэм сайхан үйлсийн
Эхлэл, бэлэгдэл болтугай!
Айл хот олноороо
Ачит түмэн ардаараа
Аймаг олноо хүндэлж
Алиа хөөрхөн багачуул нь
Айван тайван цэнгэж,
Азай буурал өвгөд нь

Амар сайхан жаргатугай! Аминь! гэхэд гэр дүүрэн хүмүүс Аминь! Болтугай!
Болтугай! гэлцэн түрэв.⁶ [121 тал] хэмээсэн нь:

Ийн бэлгэдлийн үгийг хэлэх эрхийг тэр гэрт байгаа хүндэт зочин эсвэл хамгийн ахмад настан эдлэх бөгөөд бэлгэдлийн үг хаана, хэзээ, ямар нөхцөл байдалд тохируулж хэлэхээсээ өөр өөрийн онцлогтой байна. Ийн бэлгэддэг ёс нь одоог хүртэл яг хэвээрээ уламжлагдан үргэлжилсээр байгаа билээ.

Т.Султаны “Сүмбэр уулс” хоймсон романд казах хэлт уран зохиолын зан заншлын онцлог ихээр тусгагдсан нь утга зохиолын хөгжлийн хувьд ч, үндэстний өв соёлыг хойч үедээ өвлүүлэх талаасаа ч нэлээн ач холбогдолтой чухал зүйл болсон юм. Казах хэлт уран зохиолын зан заншил туссан жишээг товчхон сонирхуулъя.

⁴) Султан Т.(1990) Сүмбэр уулс. УБ., Боть 297

⁵) Султан Т. (1990) Сүмбэр уулс. УБ., Боть 297

⁶) Султан Т. (1990) Сүмбэр уулс.УБ., Боть 212

1. Хүүхэд төрөх, эх барих ёс Т.Султаны “Сүмбэр уулс” романд:

-Бектас Айжаан хоёр хүүхэдтэй болсны ёс төр бүхнийг өөрсдийн хир чадлаар гүйцээхийг оролдов. Лалын шашны номлолоор “Чөтгөр шулам хулгайлахаас” болгоомжлон үе тэнгийн залуус айлын хүүхэд багачуулын хамт ээлжлэн долоо хоног зул барьж “шилдехана” гэгч ёсыг өнгөрөөн эх үрийг харав.⁷[67 тал]

“Шилдехана” - Шинэ хүнийг угтах баярыг Шилдехана хэмээн нэрлэдэг. Энэ нь хөрш саахалтынхан бүгд ээлж ээлжээр цугларч шинэ хүнийг долоо хоног сахидаг зан үйл бөгөөд зарим нутагт төрсөн эх үр хоёрыг тэнхэрсний дараа “Шилдехана” баярыг хийдэг ёс ч бий. Одоо үед эх үр хоёр тэнхэрсний дараа энэхүү баярыг хийх нь элбэг болсон байна.

Шинэ хүнийг эх барьж авсан хүнийг “Киндик шеше” буюу “Хүйн ээж” гэж нэрлэнэ. Хүйн ээж шинэ хүний Шилдехана өнгөрсний дараа угаалга хийж, өлгийдөх зан үйл үйлдээд нэр хүндтэй ахмад хүн нэр өгнө. Өлгийтэй хүүхдийн чихэнд ойртож өгсөн нэрийг дуулдахаар гурвантаа хэлнэ. Ийнхүү ирсэн зочдод “Тышты ма” буюу шинэ хүний идээний дээж чихэр жимснээс жижиг дөрвөлжин даавуунд боож ирсэн зочдод бүгдэд нь тарааж өгнө. Ийнхүү өгөхдөө хөгшид өвгөдийн насыг хайрлаг, хэмээн тараадаг заншилтай. Нэр хүндтэй ахмад хүн нэр өгдөг энэ ёс одоо хэвээрээ байгаа ч орчин үед өөрийн өвөө, эмээ, аав, ээж гээд өөрийн ойр төрлөөрөө шинэ хүнд нэр өгүүлэх нь илүү олонтой болсон байна.

Бесик-Модон өлгий ор

“Нимгэн торгон хөнжлөөр бүтээсэн модон өлгий орон дээр байсныг сая л анзаарав. Гэрийн эзэгтэй модон өлгийг яльгүй хөдөлгөн зөөлөн бүүвэйлэвч нялх хүүхдийн “ингаа-ингаа” хэмээх эгдүүтэй дуу намдсангүй. Залуу эх модон өлгийг аяархан өргөж орны урд тавьснаа хөнжлийг нь сөхөхөд мээмээ санасан улаан нярай амьтан тэр дороо чарлахаа больж, хошуугаа өмөлзүүлнэ. Бүсгүй баруун өвдгөөр сууж, өлгийн нуруу модонд асаж түшин эхнэрийнхээ товчийг тайлж, зүүн гараараа булбарай зөөлөн мээмээ өргөн хүүгийнхээ аманд ойртуулна.”⁸[223 тал]



“Бесик- Казах ардын эрт дээр үеэс уламжлагдаж ирсэн өв. Өвөг дээдсийн минь зуун зуун дамжин хэрэглэж ирсэн эд.” Бесик буюу модон өлгийг Дундад Ази, Кавказ, Хятадад амьдардаг ихэнх хүмүүс хэрэглэж байсан, хэрэглэсээр ч байгаа.”⁹[90 тал] Казахын модон өлгий нь тал ба хус модоор хийгддэг. Хүй нь эдгэсэн нярайг Бесик-т хэвтүүлэн өсгөдөг. Модон өлгийний голд нүх гаргасан байдаг ба түүнд хүүхдийн бөгсийг тааруулж байрлуулдаг. Нялх хүүхдийн өтгөн шингэн нь тэр нүхэнд таарч байхаар хийдэг болохоор өлгий нь норчихвий, гэж санаа зовох зүйлгүй байдаг юм. Модон өлгий нь хүүхдийн аюулгүй байдалд, дөнгөж нярайлсан эхийн гам барихад ч энэ нь тун тустай байдаг. Ингэж модон өлгийнд нь өлгийдөөд гэрийн бусад ажлаа санаа амар хийдэг билээ.

⁷⁾ СултанТ.(1986) Сүмбэр уулс.УБ., 67

⁸⁾ СултанТ. (1990) Сүмбэр уулс.УБ., 223

⁹⁾ МухтарК. (1991) Наурыз-жангырган салт-дастүрлери.Алматы., 90

“Шинэ хүнд зориулан модон өлгийг уран гартнуудад хийлгэх эсвэл ах эгчийнх нь хэрэглэж байсан өлгийд бэлгэшээж хэвтүүлдэг байна. Үүнтэй холбоотой цээр ёс ч бас байдаг.

Бесик-ийг зарж болохгүй

Ямар нэгэн шалтгаангүйгээр өөр хүнд өгдөггүй

Бесикийг хөлөн доороо байлгадаггүй

Хоосон бесикийг бүүвэйдэггүй (Хэрвээ хоосон бесик бүүвэйлвэл энэ нь үр удамгүй гэдгээ мэдэгдэж буй хэрэгхэмээн хатуу цээрлэдэг)

Бесикийг хэзээ ч онгорхой орхидоггүй. Үргэлж дээгүүр нь алчуур, хөнжлөөр нөмөргөдөг. Хэрвээ онгорхой орхивол хүүхдийн өлгийд муу муухай зүйл орно гэдэг.

Олон хүүхэдтэй айлын бесик-ийг бэлгэшээж авдаг. Энэ ёс бол яг л энэ хэвээрээ одоо ч хэрэглэгдсээр, мөрдсөөр байгаа юм.

2. Мэндлэх ёс

“Ассалаумагалейкум! хэмээн баруун гараа энгэртээ хүргэж мэхийн ёсолж, Муса өвгөнтэй керей ёсоор энгэр зөрүүлэн золгож, дараа нь бусад хүмүүстэй гар барин мэндлэв.”¹⁰[120 тал]

“Ахбайг орж ирэхэд эхнэр нь ухасхийн босож гар нүүр угаах тусгай гүцнээс гар дээр нь бүлээн ус хийж өгч, гар нүүрийн алчуур зэхэж хүндэтгэнэ.”¹¹[24 тал]

“Нэн удалгүй баяны залуу хатагтай тэвш дүүрэн мах гаргаж, тэдний өмнө тавихад гэрийн эзэнтэн хоёр алгаа дэлгэн “Аумин” хэмээн хасаг ёсоор бэлэгдлийн үг хайрлахыг хүсэхэд Саду амандаа нэг юм бувтнан удсанаа.”¹²[54 тал]

Аумин-Казахууд их ёсч, юманд нарийн журам барьдаг түмэн. Тиймээс юм болгонд ерөөл тавина. Ерөөлийн эхэнд “Аумин” хэмээн хоёр алгаа дэлгэн бэлэгдлийн үг хайрладаг. “Ерөөл бүхэн нь хувь хүн, айл гэр, улс түмэн, аж амьдралын сайн сайханд хандсан бэлгэ дэмбэрлийг агуулсан утга төгөлдөр байдаг байна.”¹³ [78 тал]

Казахууд ахмад хүн орж ирэх, эр нөхөр нь ирэхэд бүлээн ус гаранд нь хийж өгч хүндэлдэг ёстой.

3. Казах наадгайн ёс

- Орой Алтыбаханд очих уу? гэв.

-Сувдан цагаан шүдээ яралзуулан, урт сормуусаа хэдэнтээ дэлгэн, нүдээрээ инээж,

-Очноо, заавал очно! хэмээн итгэлтэй хариулав

-Өмирбек Жанбике хоёрын ээлж болоход бүсгүй турьхан гараараа оосроос нь тас зууран нүдээ анисхийж залуугийн урьдаас удтал ширтэнэ.¹⁴ [91 тал]

“Алтыбахан”-ыг нутгийн залуучууд гэрийнхээ ойр хавьдах цэвэрхэн тэгш газарт байрлуулна. Модгүй газар бол Алтыбахан тоглохын тулд гэрийг салхинаас хамгаалж тононд түшиж тавьдаг ац модыг хэрэглэдэг байна. Энэ тоглоомыг ихэнхдээ хосууд тоглодог.

¹⁰ Султан Т.(1990) Сүмбэр уулс.УБ.,120 дахь тал

¹¹ СултанТ.(1986) Сүмбэр уулс.УБ., 24 дахь тал

¹² СултанТ.(1990) Сүмбэр уулс.УБ., 54 дахь тал

¹³ МонголхүүБ.(2009) Цаст алтайн чуулган.УБ., 78 дахь тал

¹⁴ СултанТ.(1990) Сүмбэр уулс.УБ., 91 дахь тал



Энэхүү тоглоомын ерөнхий зорилго нь нэг нэгэндээ сэтгэлээ илчилж амжаагүй яваа үерхэж байгаа хос хоёрыг уулзуулах, тэднийг улам дотносуулах, ирээдүйн шинэхэн гэр бүлийн хосуудыг уулзуулах зорилготой юм. Залуучуудын хувьд хамгийн их хүсэн хүлээдэг тоглоом нь Алтыбахан байсан байна. Учир нь хангалттай уулзаж учирч чадахгүй байгаа бүсгүй, залуутайгаа дахин уулзах боломж юм. Нийгэм хөгжихийн хэрээр энэхүү Алтыбахан ч бас арай хөгжингүй болсон юм.”¹⁵ [256 тал]

Алтыбаханыг залуучууд өөрсдөө хийдэг ба бүдүүн зургаан шургаагийг гурав гурваар холбон босгож, дунд нь хөндлөн нуруу тавьж, түүнээс суран гогцоо унжуулдаг. Түүний үзүүрт хоёр хүн багтахар модон гишгүүр тавьж, дүүжин хийдэг юм. Энэхүү савлуурт залуус шөнө дөл болтол тоглоно. Ийнхүү хурим найрын үед хамгийн их тоглогддог чухал тоглоомуудын нэг нь Алтыбахан байсан ба энэ нь үр үндсээ үлдээх, үр үндсээ нэмэгдүүлэх гэсэн алсын бодлоготой тоглоом байсан бололтой. Одоо үед ч энэ тоглоомыг мартаагүй боловч яг тоглох нь ховорхон үзэгддэг.

Малчин казахын хүүхэд, залуучууд үе дамжин тоглож ирсэн уламжлалт тоглоом олон бий.

Үүнд: “шагайн наадам”, “алтыбахан”, “ах сүйек тастау”- цүү хаях, ат бэйгесі, ат ойындары, аударыспақ, бағана, бөрене, дінгекке өрмелеу,балтам тап, балуандар бапкері, жамбы ату, жаяу жарыс, желісті аттар жарысы, жорға жарысы, жіппен секіру, керілген арқан үстимен жүру, көкпар, күмис ілу, күш сынасу, қазақша күрес, палуан, қазақ күрестің түрлері, қайым айтыс, қамшыгерлік сайысы, өнерпаздар сайысы, сайқымазақ, тепкішек, түйе жарыс, шаш алуғэх мэт тоглоомын олон төрөл байжээ.

Шагайн наадам нь нүүдэлчин монголчуудтай ижилхэн байна. “ Шагай шүүрэх, морь уралдуулах, бөгцөг няслах, дөрвөн бэрх орхих, мөсөн дээр бух мөргөлдүүлэх, ташуур тавих зэргээр тоглоно. Энд нэг зүйлийг тодруулан тайлбарлах хэрэгтэй.Юу гэвэл, шагайны морь, тэмээ хоёр этгээд нь казах монгол нэрлэлтээрээ ч , буух хэлбэр дүрсээрээ ч солигдож нэрлэгддэг юм. Тухайлбал, казахуудын тайке (тэмээ) гээд байгаа нь хажуу тийшээ морины хийссэн дэл шиг сэртгэртэй босоо этгээдийг монголоор хэээ буюу таа (морь), нөгөө хотгортой босоо этгээдийг нь алц (тэмээ) гэж нэрлэдэг байхад казахар түүнийг алшы (алц) буюу морь гэнэ. Ийм л зөрөө байдаг юм.”¹⁶ [78 тал] гэж Б.Монголхүү хэлжээ.

Одоо үед хурим, баяр ёслол дээр хамгийн түгээмэл тоглогдож байгаа тоглоомуудаас “Көкпар тарту”, “ Алтыбақан”, “Теңге ілу”, “ Қыз куар” гэсэн тоглоомууд хамгийн өргөн тоглогдож байна.

4. Хуримлах, худ ураг бололцох ёс

“Хадмын талын залуус маргааш нь Айсулууг хөтлөн аавынх нь галд мөргүүлж, шар шувууны өд сөд зүүсэн домбор, утсан хуур барьсан хоёр залуу ээлжлэн дуулж, цээлхэн хоолойгоороо үүдэн дарлагын дууг уянгалуулж настангууд сургаалийн захиас үг хайрлана.”¹⁷[64 тал]

¹⁵) БикумарК.(2013) Казах халкынын салт дастурлери.УБ., 256

¹⁶) МонголхүүБ. (2009) Цаст алтайн чуулган.УБ., 78

¹⁷) СултанТ. (1990) Сүмбэр уулс.УБ., Боть 264

“Айсулуу тулганы үнс хөглөрсөн ундуй сундуй бор гэрийн баруун хаяанд өвдөг нугалж мэхийн ёслохдоо энэ гэр түүнд ер бусын дулаан санагдав.”¹⁸[64 тал]

Салем беру буюу хадмын тал, хөгшид настантай мэндлэх ёс

Бэр болж ирсэн охин хамгийн эхэлж хадмынхаа гэрийн босгыг баруун хөлөөрөө алхан орж баруун өвдөг дээрээ хагас сууж, хоёр гараа баруун өвдгөн дээрээ тавин хадам аавдаа 3 удаа бөхийж мэндэлдэг. Үүний хариуд хадам аав нь “Аз жаргал, урт удаан наслахын” ерөөлийг өргөн бэрээ хүлээн авна. Үүний дараа хадам ээж нь бэрдээ нэг халбага шар тос өгч гал руу тос дусаалгана. Ингээд бэрээ тулганы хажууд тусгайлан зөөлөн адсага дэвсэн суулгана. Энэ нь бэрийн маань ааш зан энэ зөөлөн адсага мэт намуун зөөлөн байг гэж бэлэгшээж байгаа юм. Гэхдээ одоо цагт бэрдээ халбага шар тос өгдөг нь тохиох нь ховорхон үзэгдэнэ. Хадмынхаа гэрээс идээ, будаа хүртсэний дараагаар аав ээж нь залуу хосуудад зориулан барьсан гэр сууц руу дагуулж аваачна. Ингээд өөрийн гэртээ бас л баруун хөлөөрөө орно. (Ер нь казах түмэн ямар ч үйлийг баруун гар, баруун хөлөөрөө эхлэх хэрэгтэй гэдэг.) Ингээд гэрт ороход “Шашу” цацна.

Шашу буюу идээн цацлага- Энэ нь Монгол ёсонд байдаг сүүн цацлагатай төстэй гэж хэлж болно. Аливаа үйлд сайн сайхан, амар амгаланг ерөөн бэлгэдэж идээн цацлага өргөдөг. Шинэ хүн гэрт ирэхэд [бэр ирэхэд өөдөөс нь ахмад настай хөгшчүүл] идээн цацлаа өргөдөг юм. Энэ ёс одоог хүртэл яг хэвээрээ үйлдэгдсээр байгаа]. Шашуг тавган идээгээр ихэнхдээ цацна. Үүнд: Орчин үед ихэвчлэн чихэр цацан өргөдөг бол эд зүйл ховор байсан дээхэн үед ааруул, боорцогоор өргөдөг байжээ. Монгол ёсонд сүүн цацлаа гадаа гарч, уул хадандаа өргөдөг бол казах ёсондох Шашу нь баярт үйл явдлын үеэр гэр дотор өргөн цацлагаараа ялгаатай юм.

-Айжаан хасаг ёсоор эрд гарсан эхнэрийн кокан дээл , саукеле нэртэй нөмрөг бүхий гоёмсог шовх малгай өмсөж ёс төгөлдөр гоёж гоодсон биш, хүүхэн хүний хуучин тоорцогтой, ажлын муу дээлтэй хэвээрээ байлаа.¹⁹ [69 тал]

Казахын ард түмэн гэр бүл болох, худ ураг бололцох энэ асуудлыг тун чухалчилж авч үзсээр ирсэн. Гэр бүл зохиох, үр удмаа үлдээхийн тухай бага наснаас нь эхлэн байнга зөвлөж, ярилцаж ойлгуулсаар өсгөж хүмүүжүүлдэг байна. Казах ёсонд ихэнхдээ Монигами буюу нэг эхнэр нэг нөхөр гэр бүл байх нь зонхилдог. Бусад үндэстнээс ялгардаг нэгэн том онцлог нь казахууд өвөг дээдсээ, удам судар, гарал үүслээ сайн мэддэг байсан юм. Эцэг эхчүүд нь хүүхдүүддээ багаас нь эхлээд удам судраа, гарал үүслээ хэлж, зааж сургадаг ба хүн бүр 7 үеэ сайн мэдэж байх ёстой, гэж зааж зөвлөн 7 үеийнх нь нэрийг цээжлүүлэн өсгөдөг юм. Энэ нь одоог хүртэл орхигдолгүй ирсэн том ёс заншил ба өөрийн 7 үеэ мэддэггүй казах хүүхэд бараг л байдаггүй. Энэ нь юутай холбоотой вэ гэхээр казах түмэн 7 үеэс дээших үеийн хүнтэй гэр бүл болохыг зөвшөөрдөг. Учир нь цус ойртолтоос урьдчилан сэргийлэхэд оршино. Казахууд 13 омог буюу нэг овог гэж нэрлэдэг. 7 үеийг нэг өвөг дээдэстэй хэмээн үзэж, тэр 7 үеийнхэн хоорондоо гэрлэхийг туйлын хатуу цээрлэдэг. Үүнээс ч үүдэлтэй казах залуучууд хоорондоо танилцахдаа хамгийн түрүүнд овог, ураг төрлийг нь лавладаг учиртай. Хуримлах ёсыг дотор нь маш олон хэсэгт хувааж тайлбарлах шаардлагатай болно.

Саукеле буюу сүйт бүсгүйн нүүрэвч

¹⁸) Мөн тэнд. 64

¹⁹) СултанТ. (1990) Сүмбэр уулс.УБ ., Боть 2.69

Шинэхэн буусан бэр хуримлахдаа саукеле гэх толгойн өмсгөл (малгай) өмсөх бөгөөд энэ нь тохойн хэмжээний өндөр шовх оройтой, эмжээрийг нь үнэгний сүүлээр чимэглэн гоёж болдог, малгайн оройгоос гивлүүр унжуулсан байдаг. Энэ гивлүүрээр бэрийн царайг халхалж хадмын гэрт оруулдаг. Ингээд гэртээ орж хэсэг амсхийсний дараагаар шинэ бэрийг зочдод танилцуулах ёс “Бет ашар” буюу “Гивлүүр нээх ёс” үргэлжилнэ. Нийгмийн хувьслын явцад казах эмэгтэйн гивлүүр ч мөн адил загварын хувьд бага багаар өөрчлөгдсөөр байна. Үүнийг зургаар харуулбал:



Бэрийн гивлүүр нээхээр ирсэн залуу аялгуут домбороо эгшиглүүлэн хадмын талын хамгийн ахмад хүнийг нэг нэгээр бэрд танилцуулан дуулах ба тэр тоолонд, танилцуулсан хүн бүрийн тоогоор баруун хөл дээрээ өвдөглөн сууж мэхийн ёслон хүн бүрт тус тус мэндэлнэ. Ахмад хүмүүстэй мэндэлж дуусахад өнөөх залуу шинэ бэрийн гивлүүрийг Казах ардын хамгийн хүндэтгэлтэй аялгуут Домборынхоо толгойгоор нээж олонд царайг нь харуулдаг ёстой.

“Бид энэ бүсгүйн төлөө сүй бэлэг тавьж “калын” төлөхдөө тал хөрөнгө маань илүүдсэндээ эцэг дээдсээс үлдээсэн буян хишгээ үрээгүй юм. Эсвэл хүүхнийг, үгүй бол мал хөрөнгөө буцааж авна гэв.”²⁰[65тал]

“Тэр Хатифагаас өмнө хоёр эхнэртэй боловч хасагийн Аменгер ёсоор ах дүү нар нь түрүүчийн авгайтай хүчээр суулгасан бөгөөд хоёр дахь эхнэр нь залуу харцуултай хавьтаж ойртох нь олонтой гэж битүүдээ хардаж сэрдэн сэтгэл дундуур явдаг байв.”²¹ [24 тал]

–“Мулгуу нөхөр нь бие барсан хойно хуучны “Аменгер” ёсоор Омарын ах дүүс нь Айсулууг авахаар булаацалдахад сэтгэлийн зовлонд унасан бүсгүй, Ербол минь! Миний гай зовлонг хуваалцах болоогүй юу?”²² [60 тал]

Аменгер ёс (Аменгер гэдэг нь ах юм уу дүүгийнхээ өнчирч үлдсэн эхнэр хүүхдийг нь өөр дээрээ авч, асран халамжилж байгаа тэр хүнийг хэлдэг)

²⁰) Султан Т. (1990), Сүмбэр уулс. УБ., Боть 2. 65

²¹) Монголхүү Б. (2009), Цаст Алтайн уулс. УБ., 24

²²) Мөн тэнд. 60

Нэгэнт адуу малаар худалдаж авсан эхнэрийг бэлбэсрэх үед ч үл буцааж, түүний нөхрийн талын хүнтэй албадан суулгадаг хуучны харгис ёс бий. Энэ нь эцэг эхчүүд хүү, охиноо бага байхад нь насанд хүрээд гэр бүл болгох талаар эрт сүй тавьж худ ургийн холбоо тогтоох аман хэлэлцээгээр тохирдог байв. Ингэж тохирсны дараа хүүгийн тал охины талд олон мал өгнө. Үүнийг “Халын мал” буюу “Олон мал” гэнэ. “Ардын хувьсгалаас өмнө монголын баяд ноёд ч авах бэрийн сүйнд азарга адуу авч өгдөг ёс байсан тухай Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” романдаа бичсэн байдаг. Тэгэхээр “Олон мал”-ын тухай яриа ганцхан казахуудад байсан биш нийт эсгий туургатан нүүдэлчдэд байсан ёс заншил юм. Казахуудын ураглах ёс заншил нь 15-р зуунаас нааш түүхэн уламжлалтай юм. Тэрхүү ёс журам худ ураг бололцох тухай тохиролцоо хэлэлцээнээс эхэлнэ. Тэр хэлцлийн гол утга нь олон мал өгч байж айлын хүүхнийг бэр болгох, мал хөрөнгө авч байж охиноо өгөхөд оршино”.²³ [63 тал]

“Харин эхнэр хүүхний төлөө өрсөлдөөний алс хэтийн учрыг янз янзаар тайлбарлах нь бий. Ямар ч атугай өмнөх бурангуй ёсоор эмэгтэй хүнийг урт гээг, богино жолоотой хэмээн дорд үзэж, өөрийн гэх эрх мэдэлгүй байлган, мал адгуусын адил арилжин наймаалж, зугаа цэнгэлийн бай болгосон нь бас л баяжих, нэр төр, алдар хэргэмийн төлөө аминч нэгэн бодлоос үүдэн гарсан “дээдэс” гэгчдийн дээрэнгүй санаархалтай салшгүй нөхцөлдсөн өрсөлдөөний туйл гэлтэй.”²⁴ [149 тал]

Тухайн үед хаад ноёд хоорондоо ийнхүү худ ураг бололцон, эд хөрөнгөө гайхуулан шагшуулж байсны нөгөөтэйгүүр зүс царай сайхан ядуу ардын залуу охидыг хаад ноёд хүчээр эхнэрээ болгон авч байсан харгис үзэгдэл байс байсан юм. Энэ нь баян хоосны ялгаа хэт гарч, ядуус баяд ноёдын хамаг хүнд бэрх ажлыг хийн өдрийн хоолоо олж иддэг байсантай холбоотой юм. Ядуу ардын охиныг авахын тулд нэг их инж өгөх шаардлагагүй байсан байна. Инж өгөх хэмжээ нь охины эцгийн хэргэм зиндаа, хөрөнгө буянтай холбоотой байжээ. Яах аргагүй амьдрахын эрхэнд ийнхүү охиноо хадамд гаргадаг байжээ. Чухам энэ л үзэгдлээс болж “Кыз алып кашу” буюу “Авч зугтах” үзэгдэл бараг шахуу ёс болон дэлгэрсэн билээ. “Олон мал” өгч сэтгэлгүй эмэгтэйг эхнэрээ болгон авахад түүний дурлалт залуу хайрт эмэгтэйгээ орлуулан авч зугтдаг байсан энэ байдал үнэндээ Казахын ёс заншил бус тухайн үеийн дурлалт залуусын хайр сэтгэлээ хамгаалж, сэтгэлт хүнтэйгээ ханьсан жаргахын төлөө хийдэг байсан зоригтой алхам юм. Энэ нь нэг талаасаа тун харгис хэрэг байсан боловч нөгөө талаас эцгээсээ өнчрөн үлдсэн үр хүүхдийг хойд эцгийн гар харуулахгүй, өөрийн удамд байлгаж ах дүү нар нь өөрийн хүүхэд шигээ харж хандахад их тустай байсан гэж настангууд ярьдаг байсан. Төрсөн ах эсвэл дүүгийнхээ гэр бүлийг асран хамгаалж, үр хүүхдийг нь өсгөн хүмүүжүүлдэг бас нэгэн сайн талтай байжээ.

“Олон мал”-аар эхнэртэй болох энэ ёс заншил нь Ардын хувьсгалын дараа далд хэлбэрт шилжиж, 1950- аад он хүрч бүрмөсөн утсан юм.

ДҮГНЭЛТ

Нэгдүгээрт: Монголын казахууд 1870-аад онд анх Монгол нутаг дэвсгэрт нүүдэллэн ирж суурьшсан нь, хожим өөрсдийн утга соёлыг хөгжүүлэх, Монголын нэгэн үндэстэн болох эхлэл болж өгсөн Монголын казахуудын уран зохиол хөгжих

²³⁾ Монголхүү Б.(2009) Цаст Алтайн чуулган.УБ., 63.

²⁴⁾ Султан Т. (1990), Сүмбэр уулс. УБ., Боть. 149.

таатай хөрс бий болсон байна. Казахуудын өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүхий уран зохиолын хөгжилд Б.Ахтаан, Ө.Самыхаан, Б.Төлебай, Х.Тауданбек нарын зохиол бүтээл үлэмжхэн хувь нэмэр оруулсан билээ. Тэдний зохиол бүтээлд, Монгол нутагт нүүдэллэн ирж суурьшсан казах иргэдийн шинэ эх орон, цоо шинэ амьдрал, өөрчлөгдсөн амьдралын хэв маяг, сэтгэлгээ, нийгмийн онцлог уран зохиолын хөгжилд шинэ уур амьсгал, шинэ амжилт ололтыг авчиргахад ихээхэн нөлөө үзүүлснийг ажиглаж байна. Монгол дахь казахын уран зохиол социалист реализмын арга барилаар хөгжиж байсан ч өөрийн гэсэн өвөрмөц хэв маяг, ёс заншил, уламжлалаа баримталсаар амжилттай хөгжиж ирсэн байна. Тухайн үед ихэнх зохиолчид дан казах хэлээр, цөөн хэсэг нь монгол болон казах хэлээр өөрийн зохиол бүтээлээ туурвиж байсан байна. Ингэхдээ үндэсний онцлог шингэсэн, үндэсний сэтгэлгээгээ алдалгүй уянгын, жүжгийн, туульсын зохиолын төрөл зүйл үүсэж хөгжжээ.

Хоёрдугаарт: Казах үндэсний хэв маяг, соёл уламжлалыг хадгалж, шингээсэн олон арван зохиол бүтээл тасралтгүй туурвигдаж байгаа хэдий ч, түүнийг судалж шинжилсэн нь тун цөөн байна. Эрдэмтэн, судлаач Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд, зохиолч, судлаач Б.Монголхүү, Б.Бааст, судлаач Ж.Хиналган нарын бүтээлийг эс тооцвол казах хэлт уран зохиолын судалгаа, шинжилгээний ажил эхлэлийн төдий байна. Тэгэхээр Монголын казах хэлт утга зохиол казах үндэстний аж амьдрал, ёс заншлыг судлах, мэдээгүй үлдсэн зүйлийг нь мэдүүлэх таниулах, эртний ёс заншил, уламжлал нь хэрхэн хадгалагдаж үлдсэн, одоо цагт хэрхэн хувьсаж өөрчлөгдсөн, монгол ахуй, ёс заншил хэрхэн нөлөөлсөн тухай зэргийг судалж үзэхэд Монголын казахууд, Казахстан, Хятадын казахуудын аж төрөлтэй харьцуулахад өөрийн өв соёлоо харьцангуй сайн хадгалж үлдсэн нь тодорхой ажиглагдаж байна.

НОМ ЗҮЙ

Нэг. Казах хэл дээр ашигласан материал

1. Абай. (1993), Қара сөз, поэмалар. Алматы.,
2. Базылхан Б. (1977), Қазақша-Моңғолша сөздік. УБ.,
3. Базылхан Б. (1984), Моңғолша-Қазақша сөздік. УБ.,
4. Бикумар К. (2013), Қазақ халқының салт дәстүрлері. УБ.,
5. Мухтар К. (1991), Наурыз- Жаңғырған салт дәстүрлер. Алматы.,
6. Наурызбай А. (2013), Қазақтың дәстүрлі атаулары. Алматы.,
7. Шынай Р. (2011), Салт-Сана. УБ.,
8. Сейіт К. (2007), Қазақ халқының тұрмысы мен мәдениеті. Алматы.,
9. Сейіт К. (2013), Қазақ халқының салт дәстүрлер. Алматы.,
10. Султан Т. (2012), Ата таным. 7 том. УБ.,

Хоёр. Монгол хэл дээр ашигласан материал

11. Гаадамба Ш. (1989), Утга зохиолын онолын үндэс. УБ.,
12. Галбаатар Д. (2001), Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд. УБ.,
13. Галбаатар Д. (2002), Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь. Токио.,

14. Галбаяр Г. (2004), XX зууны монголын уран зохиолын хөгжлийн үе шатууд.УБ.,
15. Дулам С. Хасбаатар Ц. (1980), Уран зохиолын онолын үүд. УБ.,
16. Монголхүү Б. (2009), Цаст Алтайн чуулган.УБ.,
17. Султан Т. (2012), Зохиолуудын 10 боть.УБ.,
18. Хиналган Ж. (2007), Бүргэдийн дууллыг хэлэлцсэн нь.УБ.,
19. Хиналган Ж. (2007), XX зууны монголын казах хэлт уран зохиолын үүсэл, хөгжил, төлөвшил.УБ.,
- 20.Энхбаяр С. (2005), Утга зохиолын онол.УБ.,

Гурав. Эх зохиол

22. Султан Т. (1986), Сүмбэр уулс. УБ.,
23. Султан Т. (1990), Сүмбэр уулс.Боть2.УБ.,
24. Бааст Б. (2008), Ахтаан Бүргэд Бид гурав. УБ.,

Дөрөв. Тогтмол хэвлэл, сонин сэтгүүл

25. Бааст Б. (1965), “Соёл утга зохиол”.№41
- 26.Утга зохиол урлаг. (1987). №23.УБ.,
27. Шугыла.(1980-1990). Монголын зохиолчдын эвлэлийн хорооны Өлгий дэх салбар.

SUMMARY

When studying Mongolian literary development history in the XX-th century, the research on Mongolian Kazakh literature hasn't been systematically carried out. To fill in this void, I have chosen to study the topic and intended to draw it into active circulations of literary research. I find the novel “The Mount Sumberu” particularly interesting that Kazakh nation`s culture and traditions have been lively reflected on it. Nowadays Mongolian-Kazakh literary research is still in its early stages unless considering some works by Ts.Damdinsuren, D.Tsend, both famous scholars & researchers, B.Mongolkhuu, B.Baast, - writers. J.Khinalgan,Ph.D. This little research aims to clarify Kazakh literature& cultural values to to readers and researchers.